



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.01.21 №03 (10732)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР УНГАР УЛСЫН ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Др.Борбала Обрушанскийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хоёр улсын харилцаа, тэр дундаа батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.

Батлан хамгаалахын сайд хэлэхдээ “Унгар Улсаас Монгол

Улсад суух Элчин сайдаар Монголын ард түмний талаар өргөн мэдлэгтэй түүхч, судлаач, эрдэмтэн хүн томилогдон ажиллах болсонд талархалтай байгааг онцлон тэмдэглэв. Мөн Монгол Улс, Унгар Улстай дипломат харилцаа тогтоогоод 70 гаруй жил болсон. Иймд цэргийн салбарт хамтран ажиллах эрх зүйн орчин, хамтын ажиллагаа явуулах бүх нөхцөл бололцоо бүрдсэн тул харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлэх өргөн бололцоотой гэдгээ илэрхийлээд,

цаашдын ажилд нь амжилт хүссэн юм.

Элчин сайд Др.Борбала Обрушанский Батлан хамгаалахын сайдад хариу талархал илэрхийлээд, Монгол Улстай тогтоосон хамтын ажиллагаа олон жилийн турш тасралтгүй хөгжиж ирсэнд баяртай байгаагаа илэрхийлэн, цаашид хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, тэр дундаа цэргийн боловсрол, эрүүл мэнд, түүх, эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх хамтарч ажиллахаа мэдэгдлээ.

ЗХЖШ-ЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ БНТУ-ЫН ЦЭРГИЙН АТТАШЕТАЙ УУЛЗЛАА

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг БНТУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Цэргийн атташе, хурандаа Өзгүр Үнсальг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр тэр бээр томилолтынхоо хугацаанд хоёр улсын Батлан хамгаалах салбар, тэр дундаа Зэвсэгт хүчний хамтын ажиллагааг улам хөгжүүлэх талаар хичээн ажиллахаа мэдэгдэв.

ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг атташэд хандан Монгол Улсад ажиллахаар томилогдсон нь баяр хүргэж, амжилт хүсээд хоёр улсын Зэвсэгт хүчний цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр санал солилцсон юм.

Хурандаа Өзгүр Үнсальг нь БНТУ-аас



Монгол Улсад албан томилолтоор ажиллаж буй гурав дахь цэргийн атташе юм.

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙГ АРИЛГАХАД ОРОЛЦСОН ЗЭВСЭГТ ХҮЧНҮҮДИЙН ТУРШЛАГА

Хөвсгөл аймгийн Ханх суманд энэ сарын 12-нд хүчтэй газар хөдлөлт болж, 6.5 баллын чичирхийлэл Булган, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл болон нийслэл орчимд хүчтэй мэдрэгдсэн. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.9 дэх заалтад “Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Засгийн газрын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд гамшгийн үед аврах, хор уршигийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд Зэвсэгт хүчнийг татан оролцуулах

шийдвэр гаргана” гэж заасан байдаг.

Иймд тангараг өргөсөн цэргийн алба хаагчид байгалийн гамшиг тохиолдсон үед бэлэн байдлыг хангаж, үүрэг хүлээх ёстой. Сүүлийн томоохон жишээ гэхэд 2018 онд Баян-Өлгий аймагт болсон үерийн үеэр Зэвсэгт хүчний ангиуд иргэдийн амь насыг аврах ажиллагааг амжилттай гүйцэтгэсэн. Үүнтэй адил олон улсад байгалийн элдэв гамшиг тохиолдсон үед Зэвсэгт хүчнээ дайчилдаг.

(Үргэлжлэл нь VII нүүрт)

БОДЛОГО, ЗОРИЛТ

С.Ганбямба: 2021 ОНД БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛНЭ

2021 он “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх гарааны бөгөөд эхний үр дүнг батлан харуулах жил байх болно

БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа С.ГАНБЯМБАТАЙ Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжлийн асуудлаар баримталж буй бодлогын талаар ярилцлаа.

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан 2021 онд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд ямар гол ажил, арга хэмжээ хэрэгжих вэ?

—Энэ оны хувьд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлэх гарааны жил юм. Тиймээс БХЯ энэ оны үйл ажиллагааныхаа үндсэн зорилгыг “Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үндсэн дээр улс орныг батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангана” хэмээн тодорхойлж, нэлээд ажил, арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Юуны түрүүнд Батлан хамгаалахын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэх ажлыг дурдах нь зүйтэй байх.

Энэ онд бид Зэвсэгт хүчний тухай, Тагнуулын байгууллагын тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Газрын төлбөрийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөөд байгаа юм. Үүнийг хууль тус бүрээр нь тайлбарлавал уншигчдад илүү ойлгомжтой байх болов уу.

Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж байна. Энэхүү хуулиар “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хийж байгаа юм. Шинэ зохицуулалтаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник

хэрэгслийг, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа цэргийн алба хаагч залуусын цалин, орлогыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого нэмэгдэх шинэ эх үүсвэр бий болж, тодорхой хөрөнгө төвлөрүүлж, Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзэж байгаа.

Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд 2015 онд Тагнуулын байгууллагын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 95 жилийн түүхтэй цэргийн тагнуулын байгууллагыг Тагнуулын ерөнхий газрын бүтцэд шилжүүлсэн нь олон улсын жишиг, стандарт, Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлагад нийцээгүй буруу шийдвэр болсныг залруулах асуудал бидэнд тулгарсан. Хуулийн энэхүү гажуудлыг арилгах, түүнчлэн Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд УИХ-аар 2015 онд батлагдсан Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг, 2016 онд шинэчлэн батлагдсан Батлан хамгаалахын багц хуулийн шинэчлэл, өөрчлөлттэй нийцүүлэх, эрх зүйн цогц байдлыг хангах үүднээс Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм. Үүний үр дүнд Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, нэгтгэл, анги, салбарын ерөнхий цэргийн тагнуулын дарга, салбар, нэгжийг иж бүрэн, мэргэжлийн удирдлагаар удирдан зохион байгуулах боломж бүрдэхийн зэрэгцээ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн цэрэг-улс төрийн тагнуулын мэдээллээр төр, засгийн болон Зэвсэгт хүчний удирдлагыг шуурхай, тасралтгүй хангах нөхцөл бүрдэнэ.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЭЛЧИН САЙД КЛЕЧЕСКИ ЗАХИДАЛ ИЛГЭЭЖЭЭ

Афганистан Улсад явагдаж буй ажиллагаанд үүргээ гүйцэтгээд ирсэн Монголын энхийг сахиулагчдад хандан АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл С.Клечески мэндчилгээ дэвшүүлж, захидал ирүүлжээ. Захидлыг бүрэн эхээр нь хүргэж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багийн захирагч, дэд хурандаа Б.Олзбаярт.

Монголын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багийн офицер, цэргүүд ээ!

Албан үүргээ амжилттай гүйцэтгээд ирсэн та бүхэн эх орондоо тавтай морилно уу! Өнгөрсөн 6 сарын туршид та бүхэн Афганистан дахь “Шийдвэртэй дэмжлэг” сургалт дадлага болон байлдааны ажиллагаанд оролцоод, аюул осолгүй эргэн ирсэн тухай сонсоход

маш их баяртай байна.

Өмнө нь та бүхнийг үдэж, тосох бүрт онгоцны дэргэд хүн нэг бүртэй уулзан мэндлэх завшаан надад тохиодог байсан. Цар тахлын дараа та бүхэнтэй биелчлэн уулзаж, гар барих боломж олдох хүртэл энэхүү мэндчилгээг маань хүлээн авна уу.

Монгол Улсдаа төдийгүй олон улсын энх тайван, тогтвортой байдлын төлөө оруулж буй та бүгдийн хувь нэмрийг нэг бүрчлэн онцлон тэмдэглэж, талархааг хүсэж байна. Монгол цэргүүд Ирак, Африк, Афганистанд энхийг дэмжих ажиллагаанд удаа дараа оролцон, олон улсад мэргэжлийн гайхалтай нэр хүндийг олсон билээ. Монголын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багийн гишүүд та бүхэн тэрхүү нэр хүндийг улам бат бэх болгон мөнхлөхөд өөрсдийн хувь нэмрийг орууллаа.



Өнгөрсөн хугацаанд, ялангуяа шинэ жил, баяр ёслолын үеэр гэр бүлээсээ хол байх ямар хэцүү байсныг би гадарлаж байна. Та бүгдийн төлөө, Монголын Зэвсэгт хүчний төлөө, Монгол Улсын төлөө гэр бүлийнхний тань

үзүүлсэн тууштай дэмжлэг, тэвчээр хатуужилд талархал илэрхийлэе. Энэ бүх амжилт, үр дүнг тэдний дэмжлэгийгээр төсөөлөхийн аргагүй юм.

Эцэст нь би АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын хүндтэй

албыг хашиж буйгаа нэр төрийн хэрэг хэмээн үздэгээ хэлэхийг хүсэж байна. Монгол Улс болон АНУ нь Стратегийн түншлэлийн харилцаанд хүрсэн нь мэдээж гайхалтай зүйл. Гэхдээ миний хувьд, ялангуяа КОВИД цар тахлын энэ хүнд хэцүү үед монгол анд нөхөд, хамтрагч нартайгаа тогтоосон бат бэх харилцаагаар хамгийн их бахархаж байна. “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэдэг. АНУ болон миний бие хүнд цаг үед Монгол нөхдөдөө найдаж болно гэдгийг сайн мэднэ. Үүнтэй адил АНУ ч мөн та бүхэнтэй мөр зэрэгцэн ирээдүйн саад бэрхшээлийг хамтдаа даван туулна гэдэгт Монгол Улс итгэж болно.

Ингээд дахин баяр хүргэе! Эх орондоо тавтай морил.

Хүндэтгэсэн, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл С. Клечески

Д.Жаргалсайхан: БИД УЛС ОРНЫГ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ОРОЛЦОЖ БАЙНА

Анх 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Барилгын цэргийн ерөнхий газар байгуулагдаж, улмаар олонтон бүтээн байгуулалтын ард гарч байсныг түүх гэрчилнэ. Эдүгээ ч уг замнал үргэлжилж байна. Иймд Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын дарга, хошууч Д.ЖАРГАЛСАЙХАНТАЙ уулзаж, тус удирдах газраас цаашид хийх ажлуудын талаар ярилцлаа.



Барилга-Инженерийн цэргийн удирдах газрыг байгуулсны зорилго, ач холбогдол юу вэ?

-Монгол Улсын Засгийн газраас эх орныхоо нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж үйлдвэржүүлэх, дэд бүтцийг сайжруулах, иргэдийн орлого, амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үүднээс бүс нутагт тодорхой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж улсаа хөгжүүлэх стратегийн ач холбогдол бүхий томоохон бүтээн байгуулалтуудыг шат дараатайгаар хийж эхлээд багагүй хугацаа өнгөрлөө. Энэ хүрээнд Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, байгууллагуудыг улс орныг хөгжүүлэх стратегийн ач холбогдол бүхий томоохон бүтээн байгуулалтын ажилд эрчимтэйгээр оролцуулах болсон. Тэр ч утгаараа сүүлийн жилүүдэд инженер, барилга-инженерийн ангиуд төмөр зам болон барилга байгууламжуудыг барьж, газрын тосны үйлдвэрийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийг сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд идэвх, чармайлттайгаар хэрэгжүүлж байна. Эдгээр үр дүн, хэрэгцээ шаардлагыг үндэслэн УИХ-ын 2020 оны хаврын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрыг байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Зэвсэгт хүчний өнгөрсөн оны онцлог үйл явдлаар тодорсон “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн 416.1 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дурдахгүй байх аргагүй. Энэ бол монгол цэргүүд ямар ч нөхцөлд аливааг хийж бүтээдэг юм байна гэдгийг тодоор харуулсан бодит жишээ болсон. Тус бүтээн байгуулалт энэ онд хэрхэн өрнөх вэ?

-Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ төмөр зам" төслийн "Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн 416.1 км төмөр замын бүтээн байгуулалтын доод бүтцийг барих ажилд ерөнхий гүйцэтгэгчээр, дээд бүтцийн ажилд туслан гүйцэтгэгчээр оролцож байгаагаас гадна 60 орчим аж ахуйн нэгж, байгууллагын хамтын хүчээр мэргэжлийн өндөр түвшинд тогтоосон хугацаанд үүргээ

амжилттай гүйцэтгэж байгааг дурдах нь зүйтэй байх. Эл бүтээн байгуулалтын доод бүтцийг барих нь маш их хүн хүч, цаг хугацаа, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж шаардсан ажил байлаа.

Энэ хүрээнд бид нийт 25 сая м.куб газар шорооны ажил, 595 ширхэг ус зайлуулах хоолой, гүүр, зөрлөг, өртөөний барилгыг барьж дууссан. Үргэлжлүүлээд дээд бүтцийн 200 гаруй км замыг угсрах ажлыг хийж гүйцэтгэж байна. Тиймээс Зэвсэгт хүчний түүхэнд тодоор үлдэх үйл явдлын эхлэл нь энэхүү төмөр зам мөн гэж хэлж болно. Бид энэ оны 3 дугаар сар гэхэд төмөр замын дээд бүтцийн ажлыг бүрэн дуусгаж захиалагч талд хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна. Мөн энэ онд

ажилласны үр дүнд мэргэжлийн боловсон хүчин дутмаг, хувь хүний дадлага, ур чадвар хангалтгүй зэрэг дутагдалтай асуудлыг богино хугацаанд шийдвэрлэсэн. Улмаар ажлын ахиц, гүйцэтгэл цаг өнгөрөх тусам сайжирч байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын тайван цагийн орон тоогоор үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх үүднээс зорилтот сургалтуудыг явуулах орчин, материаллаг баазыг бүрдүүлэн удирдлагаар хангаж ажилласнаар ирэх жилүүдэд инновацид тулгуурласан дэвшилтэт шийдлийг Зэвсэгт хүчинд нэвтрүүлж, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцуулахаар төлөвлөж байна. "Шинэ төмөр зам" төслийн хүрээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах зорилгоор төмөр замын доод болон дээд бүтцийн барилга угсралтын ажил, арга технологи, аргачлал, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн хангах чиглэлээр "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани, "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэг болон ОХУ-ын Эрхүү хотын Зам тээврийн их сургууль, "Инженерийн цэргийн холбоо" ТББ, "МКЛ" сургалтын төв, "Хүний аюулгүй байдлын академи", "Английн Пандрол" компанийн төлөөлөгчийн газар зэрэг байгууллагатай хамтран онолоор болон ажлын талбар дээрх дадлага хэлбэрээр сургалтуудыг зохион байгуулж байна.

Ингэснээр барилга-инженерийн ангиудын бие даан үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Түүнчлэн Монгол Улсын иргэн цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албыг хаах хугацаандаа зам, барилгын мэргэжил эзэмшиж бүтээн байгуулалтын ажилд оролцсоноор мөнгөн хуримтлалтай болох боломжийг нэмэгдүүлсэн. Сонирхуулахад, Зэвсэгт хүчин болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд 2019 онд 7.136.015 м.куб газар шорооны ажил буюу нийт ажлын 28 хувийн гүйцэтгэлтэйгээр хийж байсан, харин өнгөрсөн онд 18.374.905 м.куб буюу 72 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн нь

Бид Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн чадавхыг бэхжүүлж, улсыг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад оролцуулах, олон улсын хүмүүнлэгийн болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэхээр алсын хараагаа тодорхойлоод байна. Энэ хүрээнд төмөр замаас гадна төмөрлөгийн болон хүдэр, нүүрс боловсруулах үйлдвэр, усан болон дулааны цахилгаан станц, усжуулах суваг, хийн хоолой барих зэрэг ажилд оролцохоор төлөвлөж, судалгаа шинжилгээгээ эхлүүлсэн.

эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлж, "Сайншанд-Баруун-Урт-Хөөт" чиглэлийн 400 гаруй км төмөр зам барих ажлыг цар тахлаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийн дагуу зөвхөн монгол инженерүүдийн оюун ухаан, хүч хөдөлмөрөөр хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

Энэ салбарт ажиллах боловсон хүчний хувьд ямар бодлого барьж байгаа вэ?

-Зэвсэгт хүчний мэргэжлийн офицер, ахлагч нараас гадна цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжил олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, өөрийн хүсэл сонирхолыг нь харгалзан бүрэлдэн байгуулалтын ажилд оролцуулж байна. Үүнээс гадна барилга-инженерийн ангиудын үүрэг гүйцэтгэх чадавх, албан тушаалтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч

манай боловсон хүчний ажиллах чадвар хэрхэн өссөнийг харуулж байна.

Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын алсын хараа юу вэ?

-Бид Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн чадавхыг бэхжүүлж улсыг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад оролцуулах, олон улсын хүмүүнлэгийн болон энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэхээр алсын хараагаа тодорхойлоод байна. Энэ хүрээнд төмөр замаас гадна төмөрлөгийн болон хүдэр, нүүрс боловсруулах үйлдвэр, усан болон дулааны цахилгаан станц, усжуулах суваг, хийн хоолойг барих зэрэг ажилд оролцохоор төлөвлөж, судалгаа шинжилгээгээ эхлүүлсэн.

Баярлалаа. Та бүхний ажилд амжилт хүсье.
Дэд ахлагч Т.ИДЭР

ДОТООД ХЯНАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГӨВ

БХЯ-ны Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газраас "Байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулах, үр нөлөөг дээшлүүлэх" сэдэвт цахим сургалтыг энэ сарын 18-19-нд зохион байгууллаа. Сургалтад Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, ХШУДАГ-ын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, Батлан хамгаалахын хяналт шалгалтын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон БХЯ-ны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн 80 гаруй байгууллагын удирдлага, санхүү, ар тал, дотоод хяналт, шалгалт хариуцсан 300 орчим албан тушаалтан оролцлоо.

Хурандаа Ж.Болдбаатар цахим сургалтыг нээж хэлсэн үгэндээ "Энэхүү сургалт нь COVID-19-ийн үед цахимаар явагдаж байгаагаараа онцлог. Батлан хамгаалах салбарын хэмжээнд байгууллагуудад дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулахын ач холбогдлыг ойлгуулах, албан тушаалтнуудын төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалттай холбоотой үүргийн биелэлт болон санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил, дутагдлыг засч залруулахад энэхүү сургалтын зорилго, үр нөлөө чиглэгдэж байна" гэлээ.

Цахим сургалтын үеэр Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Монголын мэргэсэн дотоод хяналтын институт болон Батлан

хамгаалах яамны ХШУДАГ-ын дотоод аудит хариуцсан албан тушаалтнууд онлайнгаар илтгэл, лекц тавьж хэлэлцүүлсэн юм. Төгсгөлд нь хурандаа Б.Эрхэмбаяр "Батлан хамгаалахын сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хяналт, шалгалтын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэх дотоод аудитын хорооны хурлаар хяналт, шалгалтын дүнг хэлэлцэн шийдвэрлэж, зөрчил дутагдлыг арилгах, таслан зогсоох, харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах тэднийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулахад онцгой анхаарч шат дараатай ажлуудыг хэрэгжүүлж байгаа" гээд сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өглөө.

Дашрамд дурдахад, 2020 онд Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Батлан хамгаалахын дотоод, хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, "Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын журам" тус тус шинэчлэн батлагдаж, сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт төсөвт болон төрийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хууль, тогтоомжийн дагуу үр нөлөөтэй хяналт, шалгалтыг нэгдмэл төлөвлөлт, уялдаа холбоотойгоор явуулах зохион байгуулалтын асуудлууд шийдвэрлэгдэж, эрх зүйн орчин бүрдсэн аж.

БИЕЙН ТАМИР, СПОРТ ХАРИУЦСАН АЛБАН ТУШААЛТНУУД ЦАХИМААР ХУРАЛДЛАА

ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, тус хэлтсийн Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ нарын албаны хүмүүс Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын биеийн тамир, спорт хариуцсан албан тушаалтнуудтай цахимаар хуралдлаа.

Хурлын эхэнд хурандаа Ш.Гантулга 2021 оны сургуулийн жилд Зэвсэгт хүчин сургалтын шинэ тогтолцоогоор сургалт бэлтгэлээ явуулах тухай, цэрэгжлийн спортын төрлүүд эмблемтэй болсон тухай, бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүйн бэлтгэлжилт гэдэг цэргийн хүний үндсэн үзүүлэлт учир энэ чиглэлд биеийн тамирын офицерууд гол анхаарлаа хандуулах гээд хэд хэдэн чиглэлээр үүрэг, даалгавар өгөв.

Тэр тусмаа ахлагчийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 2020-2021 оны хичээлийн жилийг Зэвсэгт хүчний ахлагчийн бие бүрэлдэхүүний бие бялдарын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил болгон зарласан. Тиймээс нэгтгэл, анги, байгууллагын биеийн тамир, спорт хариуцсан албан тушаалтнууд эл зорилттой уялдуулж үйл ажиллагаагаа чиглүүлэн эрчимжүүлэх ёстойг онцоллоо.

Хурандаа Д.Цог-Эрдэнэ 2020 онд зохион байгуулагдсан спорт-нийтийн биеийн тамирын тэмцээний нэгдсэн дүн, онцлог, ач холбогдлыг дурсаж 2021 онд зохион байгуулагдахаар төлөвлөсөн уралдаан, тэмцээнүүдийн талаар мэдээлэл өглөө. Тэрээр ирэх 2-3 дугаар сард цэрэгжлийн нэлээдгүй уралдаан, тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөсөн ч цар тахлын нөхцөл байдлын улмаас есдүгээр сар болон түүнээс хойших хугацаанд явуулна. Ингэхдээ Зэвсэгт хүчний тухай хуулийн дагуу төрийн цэргийн командлалууд шинээр байгуулагдсантай холбогдуулан Зэвсэгт хүчний аварга шалгаруулах уралдаануудын журамд тодорхой өөрчлөлт орж байгааг онцлон тэмдэглэв. Мөн Зэвсэгт хүчний аварга шалгаруулах марш тактикийн тэмцээний журмыг олон улсын цэрэгжлийн спортын дүрэм, заавар, жишээ, баримтуудыг үндэслэн хэд хэдэн уралдааны гүйцэтгэлд торгуулийн тойргийг нэмж оруулж байгааг нэгтгэл, ангиудын биеийн тамирын офицеруудад ярилаа. Төгсгөлд нь 2021 он бол Зэвсэгт хүчний хувьд түүхэн жил. Энэ түүхэн жилийн төгсгөлд явагдах уралдаан, тэмцээнд бие бүрэлдэхүүнээ сайн бэлтгэж оролцуулахад онцгой анхаарахыг захисан юм.

“СОЁМБО” РЕДАКЦ МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮДТЭЙ ХАМТАРЧ АЖИЛЛАНА

Төрийн батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг нийгэмд нэгдсэн удирдлага, төлөвлөлтөөр сурталчлан таниулахын тулд Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын тушаалаар Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний төв хэвлэл "Соёмбо" сонин болон "Дуулга" студийг нэгтгэн "Соёмбо" редакц явуулах бэлтгэлтэй холбогдуулан "Соёмбо" редакцын удирдлага өнгөрсөгч Баасан гарагт Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбооны удирдлага, хэвлэл мэдээллийн зарим байгууллагын төлөөлөлтэй уулзаж, хамтран ажиллах талаар санал солилцов.

Уулзалтын эхэнд "Соёмбо" редакцын дарга, ерөнхий редактор, хурандаа С.Төмөрхуяг "Тус редакц нь шинэ бүтэц, орон тоогоор үйл ажиллагаа явуулаад удаагүй байгаа энэ үед түүнчлэн Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн түүхт 70 жилийн босгон дээр та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байгаагаа илэрхийлэв. Өнөөдөр та бүхнийг нэгдүгээрт, шинэ бүтэц, орон тоогоор үйл ажиллагаа явуулж эхэлж байгаатай

холбогдуулан шинэ бодлого, зорилт тавьж, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг шинээр боловсруулахад мэргэжлийн байгууллагуудын саналыг тусгах, хоёрдугаарт, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд энэ онд тохиох түүхэн үйл явдлууд болох Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн түүхт ойн хүрээнд зохион байгуулах арга хэмжээнүүдийг нийгэмд хүргэх, гуравдугаарт, тус редакцын сурвалжлагч, сэтгүүлчдийг мэргэжлээр дадлагажуулах чиглэлээр холбогдох сургалтуудад хамруулах замаар танай мэргэжлийн байгууллагуудтай тогтоосон харилцаагаа сэргээн, хамтран ажиллах зэрэг зорилготойгоор энэхүү уулзалтыг зохион байгуулж байна" хэмээн онцолсон.

Уулзалтаар "Соёмбо" редакцаас 2021 онд дээрх мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах бодлого чиглэл, төлөвлөж буй арга хэмжээ, сургалт дадлага, үйл ажиллагаануудынхаа талаар мэдээлэл өгч, харилцан санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрлээ.

ШАНДАС СОРЬСОН ЖИЛД

ШАЛГАРЧ ЧАДСАН АМЖИЛТ ТЭДНИЙХ

Шандас сорьсон жилд шалгарч чадсан амжилт тэднийх хэмээн гарчигласан нь учиртай. Өнгөрөн одсон 2020 онд дэлхий нийтэд цар тахлын аюул нүүрлэж хэн бүхэнд цаг үетэйгээ тохирч шинэ орчин нөхцөлд ажиллаж хөдөлмөрлөх, удирдан зохион байгуулах шаардлага тулгарсан. Байнгын бэлэн байдал, бэлтгэл сургуулилттай

харанга дэлдээд байгаа үед Чингэлтэй дүүрэгт зохион байгуулсан хөл хорио тогтоох нэгдсэн дадлага, сургуульд дэмжлэг үзүүлсэн. Эл арга хэмжээнд тус ангиас 150 цэргийн алба хаагч оролцож, дүүргийн 19 дүгээр хороо Дамбадаржаагийн гүүрнээс Жигжидийн гүүр хүртэл нийт 10 км урт зурвасын хамгаалалтыг зохион байгуулах



байхыг шаарддаг цэргийн албанд энэ нь хүндрэлтэй хэдий ч нөхцөл байдалд дасан зохицох чадвартай цэргийн алба хаагчид нэгэн шинэ алхам хийж үүнийг албандаа хэвшүүлж чадсан гэлтэй. Зэвсэгт хүчний 350 дугаар ангийг онцлохыг хүслээ. Томилотт аван тус ангид очиход ангийн 15 хувь буюу удирдлагын бүрэлдэхүүн нь ажиллаж байсан юм.

Монгол Улсад коронавирусын тохиолдол илэрсэн цагаас эхлэн хөл хорио, онц байдлын бүхий л хугацаанд дүрэм журмыг чанд сахиж байсан хэдий ч үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэн, цэргийн сургалт бэлтгэлийг мэргэжлийн болон цэрэгжлийн уралдаан, тэмцээнүүдтэй уялдуулан зохион байгуулж, цэргийн алба, сахилга бат, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, мэдээлэл сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажил, сэтгэл зүй, ар тал, техникийн хангалтыг тасралтгүй явуулснаар дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа бүрэн дүүрэн хангаж, 2020 оноо амжилттайгаар үдсэн байна.


Энэ талаар ангийн захирагч, хурандаа Ж.Сүх-Очир "Цэргийн анги гэдэг бол бэлэн байдал, түүнд бэлдэх сургалт бэлтгэл нэгт тавигддаг газар. Үүнд нийцэж байх үүднээс манай анги өнгөрсөн сургуулийн жилд цэргийн сургалт бэлтгэлийн стандарт, хичээлийн хөтөлбөрийг хангаж, бие бүрэлдэхүүний байлдааны үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалтуудыг тогтмол, чанартай зохион байгуулсан. Үүнийхээ үр дүнг ч үзсэн. Онцолбол, штабын дадлагуудыг цаг хугацаанд нь явуулж, ангийн команд штабын сургуулийг дотооддоо бүрэн хэмжээгээр зохион байгуулснаар ангийн штаб, офицеруудын мэдлэг, ур чадвар нэмэгдэж, ЗХЖШ-ын цогцолбор шалгалтын команд штабын сургуулиар 86 хувь буюу үүрэг гүйцэтгэх чадвартай хэмээн үнэлэгдсэн. Мөн дээрх шалгалтаар мотобуудлагын ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг "Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот, дайсны тактикийн агаарын десант, хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэл явуулах нь" сэдвээр зохион байгуулж, 92 хувь буюу "Онц" үнэлгээтэй дүгнэгдсэн. Нэгдсэн дүнгээр 89 хувь буюу үүрэг гүйцэтгэх чадвартай хэмээн үнэлэгдэн цэргийн сургалт бэлтгэлээр "Хошуучлагч анги"-ийн болзол хангасан. Биеийн тамир, спортын уралдаан тэмцээний бүх төрөлд амжилттай оролцож, нэгдсэн дүнгээр дэд байр эзэлсэн зэрэг амжилт нь тус ангийн бие бүрэлдэхүүний гар нийлэмжтэй ажиллагааны илрэл юм. Мөн энд нэг зүйлийг зориуд хэлэхэд, дээрх амжилтад ангийн бие бүрэлдэхүүн санаа сэтгэл нэгтэй байж цэвэрлэгчээсээ захирагч хүртэл бүх хүн хүчин чармайлт гаргаж, зангидсан гар шиг байсны үр дүн юм" гэв.

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд нь тайван цагт гүйцэтгэх үүрэг, бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшингээ хангах үүднээс дараах сургалт, дадлага, арга хэмжээнд оролцож. Үүнд, дэлхий дахинд аюулын

үүрэг гүйцэтгэжээ. Мөн Тулгар төр байгуулагдсаны 2229, Их Монгол Улсын 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн аж. Энэ хүрээнд нэг сарын хугацаатай ангийн 120 алба хаагч баяр наадмын талбайн 430 гаруй монгол гэр, том жижиг 250 асар майхан, хоёр урлагийн тайз, дөрвөн том дааман хаалгыг барьж, наадмын талбайн усалгаа, цэвэрлэгээ, тохижилт зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн юм. Цонжин болдог цогцолборын районд "Алтан орд" амралтын газрын бүтээн байгуулалтад 100 гаруй цэргийн алба хаагч оролцож, 1000 м.кв усан суваг, 2000 м.кв усан цөөрөм, 2 км авто замын далан шуудуу, 1000 м.куб газар шороо, 200 м явган хүний засмал замын ажил хийж хүлээлгэн өгчээ. Эдгээр нь тус ангийн бие бүрэлдэхүүний оролцсон ажлуудын нэгээхэн хэсэг юм.

Хошууч Б.БАТЦЭНГЭЛ

Олон дунд бусдыгаа манлайлж үлгэр дуурайл болдог цэргийн алба хаагчид тус ангид олон. Тэдний нэг нь Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн Цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын офицер,



Хошууч Б.Батцэнгэл

хошууч Б.Батцэнгэл юм. Тэрээр ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын 2020 оны тэргүүний офицер аж. Цэргийн хүн өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэл сайтай хийж, нягт нямбай, чин шударга байх ёстой гэсэн зарчмаар албандаа ханддаг гэх тэрээр дээр дурдсан бүхий л үйл ажиллагаанд ангийнхаа бие бүрэлдэхүүнийг удирдан оролцожээ. Үүнээс гадна салаа, салбарын жигдрэлтийн сургуулийн хээрийн гаралтууд, байлдааны буудлагатай тактикийн хээрийн дадлагыг амжилттай зохион байгуулжээ. Түүний нэг давуу тал нь ямар ч ажилд бие бүрэлдэхүүнээ удирдан оролцоходоо цэргийн дүрмийн мэдлэг, жагсаалч ажиллагаа, цэргийн алба, сахилга дэг журмыг бэхжүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго тавин ажиллаж албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажилладаг бөгөөд бусдадаа үлгэр дуурайл болж явдаг аж.

Ахмад Б.ГАНЗОРИГ



Ахмад Б.Ганзориг

Ахмад Б.Ганзориг Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн "бүтээгдэхүүн", тус ангийн анхны цэргийн алба хаагчдын нэг. Дөрвөн асар, дөрвөн гэр байхад нь тус ангид анх хөл тавьж байжээ. Энэ хугацаанд тэрээр хангах ротын техникийн орлогч, ажиллагааны офицер, ротын захирагч зэрэг албан тушаалыг тус тус хашсан. Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг. Гэргий Ө.Ханд тус ангид холбооны залгагчаар ажилладаг. Ангийн спортлог гэр бүл хэмээн цоллогдох тэд Зэвсэгт хүчний хэмжээнд болон ангид зохиогддог спортын бүхий л төрлийн арга хэмжээнд оролцож, амжилт үзүүлдэг ховорхон "авьяастай" аж. Хэн хэнийхээ ажил, мэргэжлийг ойлгох, дэмжих гээд гэр бүлийн хоёр нэг дор ажиллахын давуу тал олон. Хамгийн чухал нь бидний харах зүг, чиглэх бай нь Зэвсэгт хүчин юм хэмээн хэлж байсан. Тэрээр залуу гэр бүлд тулгардаг нийгмийн асуудалд ангийн удирдлага, хамт олон үргэлж тусалж дэмждэгт баярлаж явдгаа энэ үеэр хэлж байлаа.

Ахлах ахлагч Н.АЛИМАА

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн ахлах ахлагч Н.Алимаа. Зэвсэгт хүчинд 20 дахь жилдээ ажиллаж байгаа нэгэн. Зэвсэгт хүчний 336 дугаар ангид 14 жил тогоочоор ажиллаад тус ангид томилогдон иржээ. Цэргийн гал тогоо гэдэг цэргийн ангид хамгийн чухал нэгж байдаг. Цэргийн алба хаагч үүргээ хэр гүйцэтгэх нь тус гал тогоонд ажиллаж байгаа хүн бүрд хамаатай гэх зарчмыг баримталж ажилладаг талаараа хэлж байсан. Энэ ангийн хашаанд байгаа хүн нэг бүрийн эрүүл мэнд бидний хийсэн хоол ундаас шалтгаалж байдаг учир сургалт, дадлага, бэлтгэл, хээрийн гаралт зэрэгт тааруулж хоол хүнсээ бэлтгэдгээс гадна эрүүл, амт чанартай, тэжээллэг хоол хүнсээр цэргийн алба хаагчдаа дайлаад, гал тогооноос сэтгэл амар гаргахыг эрхэм болгодог гэнэ. Тэрээр ангийнхаа тогооч нарыг удирдан өөрийн салбарын уралдаан тэмцээнд тогтмол оролцож, ганзага хоосонгүй үлддэг гэх. Тухайлбал, хоёр



Ахлах ахлагч Н.Алимаа

жилийн өмнө зохион байгуулсан Улсын аварга шалгаруулах тогооч нарын тэмцээнд багаараа хоёрдугаар байр, ахлах тогооч нарын төрөлд гуравдугаар байр, нарийн боовны төрөлд нэгдүгээр байр эзэлж байжээ. Үүнээс гадна "Хааны эрэлд", "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан болон хээрийн сургалт бэлтгэлүүдэд тогтмол оролцдог аж.

Зэвсэгт хүчний 350 дугаар анги бол Зэвсэгт хүчин төдийгүй улсын болон дэлхийн хэмжээний спортын уралдаан тэмцээнд баг тамирчдаа бэлтгэн оролцуулж, амжилт үзүүлдэг спортлог анги. Үндсэн үүргийн

цэргийн сургалт бэлтгэлээс гадна ангийнхаа бие бүрэлдэхүүний авьяас чадварыг нээн илрүүлж, түүнийг нь дэмжиж дадлагажуулж байдаг нь үр дүнгээ өгсөөр байгаа. Тухайлбал, өнгөрсөн жил Дэлхийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнээс ахлагч Ц.Отгонтогс 70 кг-ийн жинд, дэд дэлхийн аварга болцгоож, Ц.Жавхлантогс хүрэл медаль тус тус хүртсэн. Словени Улсын Копер хотод зохион байгуулсан Таеквондогийн Дэлхийн цомын аварга шалгаруулах 12 дахь удаагийн тэмцээнд буудагч, дэд ахлагч Л.Тэмүүлэн амжилттай оролцож онцгой чадварын төрөлд мөнгөн медаль, 57 кг-ийн жинд алтан медаль, Дэлхийн цом тус тус хүртэн аварга болж эх орон Зэвсэгт хүчин, ангийнхаа нэрийг дуурсгасан. Мөн дэд ахлагч Л.Тэмүүлэнгийн гаргасан амжилтыг өндөрөөр үнэлэн "Олон улсын хэмжээний мастер" цолыг хүртээжээ.

Афганистан Улсад зохиогдсон Данкон холын зайн гүйлтийн тэмцээнд



Ахлах ахлагч Ц.Баясгалан

ахлах Д.Пүрэвням I байр, Х.Алтаншагай III байр, Монголын хамгаалалтын буудлагын холбооны цомын аварга шалгаруулах тэмцээнд ахлах ахлагч Ц.Баясгалан алтан медаль, цом хүртсэн зэрэг дурдаад байвал тус ангийн спортын амжилтын цуваа урт юм. Эдгээр тамирчин, алба хаагчдын нэг нь Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн мэргэн буудагчдын тасгийн захирагч, ахлах ахлагч Ц.Баясгалан юм. Тэрээр мэргэн буудлагын тэмцээн уралдаанд Зэвсэгт хүчнээ төлөөлөн оролцдог нэгэн. Анх 2011 онд Зэвсэгт хүчний 016 дугаар нөхтгэлд байхдаа мэргэн буудлагын тэмцээнд оролцон тэргүүн байр эзэлсэн бөгөөд мэргэн буудлагын сургалтад хамрагдсанаар түүний сонирхол мэргэн буудлага руу чиглэх болжээ. Хурандаа С.Түвшинбаярын шавь болсондоо үргэлж талархаж явдаг бөгөөд өдгөө тэрээр өөрөө мэргэн буудагч, сургагч багш болж өөрийнхөө мэддэг чаддаг бүхнээ бусдад зааж байгаа гэв. Тэрээр хэлэхдээ "Буудлага хийхэд дадлага сургуулиас гадна сэтгэл зүйгээ бэлдэх нь хамгийн чухал" гэсэн юм.

Д.БААСАНСҮРЭН



Д.Баасансүрэн

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн нягтлан бодогч Д.Баасансүрэн. Тэрээр Зэвсэгт хүчинд 30 гаруй жил, тус ангид ажиллаад зургаан жилийн нүүрийг үзэж байна. Тэрээр шижгэнэсэн, цэгцэрсэн залуустай ажиллах үнэхээр урамтай. Үргэлж эрч хүч авдаг хэмээж байсан. Д.Баасансүрэн "Би энгийн байгууллагад ажиллаж үзсэн. Бүтэхгүй юм байна лээ. Ангидаа, цэргийн хүүхдүүддээ их дассан байдаг юм билээ" хэмээн онцолж байв.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

Нийслэл хүрээг гамин цэргүүдээс чөлөөлж байсныг дурдахаас өмнө хятадууд Монголын автономийг хэрхэн устгаж байсан талаар энд өгүүлэе.

МОНГОЛЫН АВТОНОМИЙГ УСТГАВ

Дэлхийн нэгдүгээр дайн болон Орос оронд гарсан Октябрийн хувьсгал, Оросын иргэний дайн зэрэг үйл явдлаас уламжлан Богд хаант Монгол Улсын талаар Оросын баримтлах бодлого суларсан байна. Энэхүү эгзэгтэй үед Монголын тусгаар тогтнолыг цаашид хангах талаар Монголын ноёд, лам нарын хоорондох зөрчил хурцадсан бөгөөд 1919 оны 2 дугаар сард Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн учир битүүлэг байдлаар нас баржээ.

Хиагтын гэрээний дагуу Монголд сууж байсан Хятадын бүрэн эрхт төлөөлөгч Чен И энэхүү цаг төрийн байдлуудыг ашиглан Монголын удирдлага дахь Хятадын талыг баримтлагч Шанзав Бадамдорж, Гадаад хэргийн сайд Цэрэндорж зэрэг лам, ноёдыг өөртөө татах бодлогыг амжилттай явуулж эхлэв. Тэрбээр Монголын эдийн засаг хүндрэлтэй байсныг далимдуулан ихээхэн шан харамж олгох амлалт өгсөн ба Хиагтын гэрээгээр тогтоосон Монголын автономийг монголчууд өөрсдөө хүсэлт гарган устгах тухай 64 зүйлийн гэрээ гэгчийг боловсруулан монголчуудад тулган өгсөн байдаг.



Үүнийг Манлайбаатар Дамдинсүрэн тэргүүтэн эрс эсэргүүцэж байхад Бадамдорж, Цэрэндорж нар дэмжиж байв.

Иймэрхүү хоорондын зөрчилтэй, нэгдсэн бодлогогүй үед Хятадын генерал Сю Шүжан 1919 оны 10 дугаар сард 4000 цэрэгтэй Нийслэл хүрээнд ирж байрлажээ. Үүний араас оны эцэс гэхэд 10000 цэрэг бүхий хүч нэмж ирж байрлав. Чен И ба Сю Шүжан нар хоорондоо зөрчилдөн улмаар Сю Шүжан Чен Иг баривчлан Бээжинд хүргүүлсний дараа Монголын автономийг устгах гэрээ бичигт монголчуудыг гарын үсэг зуруулахаар цэргийн хүчээр сүрдүүлэн Бадамдорж, Цэрэндорж нарыг зөвшөөрүүлж гэрээнд гарын үсэг зуруулсан ба монголчуудын зэвсгийг хураан Монголын автономит эрхийг бүрэн устгаж байгаагаа зарлах ёслолыг Их хүрээнд хийжээ. Энэ үеэр Богд хааныг Хятадын ерөнхийлөгчийн зургагт мөргүүлэх зэргээр монголчуудыг илт доромжилсон үйлдүүдийг хийсэн юм.

Энэ үед монголчууд Хятадын цэргийн түрэмгийлэн эзэлснийг эсэргүүцэн, хөдөө орон нутагт тэмцэл өрнүүлж эхлэв. Тэмцлийн хэлбэр нь цөөн тоотой гамин цэргүүдийг зэвсэглэн дайрч устгах, цэргийн агт морьдыг булаах, цэргийн ачаа хөсгийг дээрэмдэх зэрэг хүч хэрэглэсэн аргуудаас гадна Богд хаан болон тусгаар тогтнох эрмэлзэл бүхий ноёд, лам нар гадаадын улсуудаас цэрэг, зэвсгийн тусламжийг бичгэн болон аман хэлбэрээр хүсэх зэргээр тэмцэл явагдаж эхэлжээ. Мөн үед хүрээнд тэргүүний тэмцэгч эх орончдын Хүрээний бүлэг ба Консулын бүлэг гэсэн нууц бүлгэмүүдийг байгуулж эхэлсэн. Чен И хүрээнд ирсний дараа монголчуудыг зөөлөн аргаар татах бодлогоо дахин эхэлсэн боловч Сю Шүжаны дараа цэргийн эрхийг авсан генерал Жан Циньхуй, Го Сунлин и Ма Бинюэ нар түүнд захирагдсангүй. Монгол орныг эзэлсэн гамин цэргүүд монголчуудыг дээрэмдэх, хүчирхийлэх аргаар ар тал, хангалтаа бүрдүүлж байснаас харгислал улам ширүүссэн байна. Хятадын тагнуул, мэдээлэгч, урвагч нарын тусламжтайгаар монголчуудын тэмцлийг мэдсэн хятадууд Богд хааныг гэрийн хорионд оруулж хорьсон ба дэвшилтэт үзэл бодол бүхий ноёд, лам нар ба жирийн монголчуудыг олноор нь хоморголон баривчлан хорьж, эрүүдэн шүүж эхэлжээ.

Монголын үндэсний архивт 1919 онд Нийслэл хүрээнд сууж байсан Бүрэн эрх төлөөлөгч Чэн И ба Богд хаант Монгол Улсын удирдлагатай хийсэн хэлэлцээний үеийн тэмдэглэлийн хэсэг хадгалагдаж байна. Тэрхүү тэмдэглэлд Монголын автономит төрийг устгасны төлөө Монголын ноёд, том лам, хутагт нарт мөнгөн шагнал олгох асуудлыг хэлэлцсэн бөгөөд 138 хүний нэр, цол хэргэм болон олгох мөнгөн шагналын хэмжээг заасан жагсаалтыг үйлдсэн нь хадгалагдан үлджээ. Жагсаалтын эхэнд Ерөнхий сайд, Эрдэнэ шанзав да лам Гончигжалцангийн Бадамдоржид 30 мянган лан мөнгө, Дотоод яамны дэд сайд дархан чин ван Пунцагцэрэн ба дэд сайд Да лам Пунцагдорж нарт тус бүр 15 мянган лан мөнгө, Гадаад яамны сайд, Хичээнгүй гүн Б.Цэрэндоржид 20 мянган лан мөнгө гэх зэргээр нийт 354 мянган лан мөнгө олгохоор заасан байна. 1920 онд Монголын ноёд лам нарын өөрийн хүсэлтээр автономит эрхийг устгасан. Нэгэнт хэлэлцэн тохирсон зүйл хэрэгжсэн тул мөнгөн шагналаа авсан байх магадлал өндөр юм.



БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.СҮХБААТАР

Өдгөөгөөс 100 жилийн тэртээ 1921 оны 2 дугаар сарын 04-нд Оросын генерал Барон Унгерн тэргүүтэй Монгол-Оросын цэргийн хүчин Монголын Нийслэл хүрээг Хятадын гамин цэргээс чөлөөлсөн түүхтэй.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнгээр монголчууд тусгаар тогтнолоо тунхаглан зарласан боловч хүчирхэг хөршүүд нь хүлээн зөвшөөрөөгүйгээр үл барам 1919 онд Хятадын цэргийн генерал Сю Шү Жан үлэмжхэн хэмжээний цэргийн хүч дагуулан орж ирэн Монголын автономитийг үгүй хийсэн билээ. Энэ хүнд хэцүү цаг үед Хятадын цэргийн эрхтнүүдийн хардлага сэрлдэг улам бүр хүчтэй болж, Монголын ихэс дээдсийг баривчлан хорьж, үндэсний хувьсгалт үзэл санаатай хүмүүсийг нухчин дарсан билээ. Тэр ч бүү хэл монгол цэргүүдийн зэвсгийг хурааж, Зэвсэгт хүчнийг үгүй хийсэн байдаг. Чухам энэ үеэс эхлэн монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл эрс нэмэгдэж, хувьсгалд далд бэлтгэж эхэлсэн бөгөөд гаднын улс орны дэмжлэг тусалцаа туйлын их шаардлагатай байжээ. Яг энэ цаг үед азтай ч гэмээр үйл явдал болсон нь хаант Оросын генерал Барон Унгерн Монголд орж ирсэн үйл явдал юм.

Барон Унгерн анх Монголын зүүн хойд хилээр өөрийн Азийн морьт дивизийн хамтаар хил нэвтрэн орж ирсэн. Түүний ирсэн зорилго түүхчдийн дунд их маргаан дагуулдаг. Нармай Монголыг сэргээн байгуулах зорилготой, Сибирийн атаман Семёновын тушаалаар, Японы дэмжлэгээр орж ирсэн гэх мэт янз бүрээр ярьдаг. Гэхдээ хамгийн энгийн тайлбар бол Барон Унгерн Монголыг Зөвлөлт Орос руу довтлох түшиц газраа болгосон нь түүхэн үнэн юм.

Түүний морьт дивизэд ихэвчлэн Ази гаралтай хүмүүс багтаж байжээ. Монгол, Буриад, Башкир, Казах, Татар, Хятад, Япон гэх мэт цэргүүд үүрэг гүйцэтгэсэн нь Азийн морьт дивиз

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

НИЙСЛЭЛ ХҮРЭЭГ МОНГОЛ ЦЭРГҮҮД ЧӨЛӨӨЛСӨН НЬ

нь амжилтгүй болсноор асуудлыг хүчээр шийдэхэд хүргэсэн юм. Барон Унгерн Хүрээ рүү хэд хэдэн удаагийн амжилтгүй довтолгооныг зохион байгуулсан бөгөөд 800 хүнтэй түүний дивиз 15 мянга орчим хүнтэй гамин цэргийн өмнө дэндүү хүчин мөхөстөх болов. Тиймээс Барон Тэрэлжийн зүг ухран цэргүүдээ шинээр эмхлэн зохион байгуулахаар болсон юм.

атаман Семёновын 100 мянган хүнтэй арми ирж яваа, Бароны цэргийн тоо хэдэн мянга гэх мэтээр цуу тарааж Хятадын эсрэг сэтгэл зүйн дайныг ямагт хийж байжээ.

Нийслэл хүрээг чөлөөлөх байлдааны ажиллагааны өмнө 1 дүгээр сарын 31-ний цэргийн үзлэгээр дан монгол цэргийн хоёр зуут, Монгол-Буриадын холимог нэг зуут гээд нийт гурван зуутын 250 орчим цэрэг байжээ. Нөөцөд Найдан гүний цахар цэргийн нэг зуутыг эцсийн мөчид ашиглахаар үлдээжээ.

Байлдааны ажиллагаа 2 дугаар сарын 2-ны өдөр эхэлсэн бөгөөд Саж лам, Тубанов, барга Лувсан нарын Монгол-Төвөд цэргээс бүрдсэн отряд Богд гэгээнийг суллах ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Монгол цэргүүдийн сэтгэл санааг өндөрт өргөж байлдааны ажиллагааг амжилттай болоход түлхэц өгсөн юм.

Шөнө нь монгол цэргүүдийн санаачилгаар Богд уулын ам болгонд цэрэг бүхэн нэгжээд тооноос давсан түүдэг гал асаасан нь гамингуудад Бароны тал асар их цэрэгтэй гэсэн айдсыг төрүүлж нийтээрээ сэтгэл зүйн хувьд тогтворгүй болж, зөвхөн бүслэлтийг хэрхэн сэтлэн хаашаа явах вэ гэсэн асуудлыг л бий болгожээ. Энэ аргыг монголчууд эртнээс нааш чадварлаг хэрэглэж ирсэн бөгөөд зөвхөн монгол цэргүүдээс л гарсан санаа гэдэг нь тодорхой ба магадгүй ХХ зууны цэрэг дайны түүхэнд сүүлчийн удаа амжилттай ашигласан эртний монголчуудын арга байж магадгүй юм.

Хүрээг чөлөөлөх тулалдааны хамгийн хүнд хэсэгт монголчууд л орж тулалдааны өмнө ямагт манлайлан газар орны байрлалаа сайн мэддэг гэдгээ ашиглан хүрээ рүү орж болох зай завсраар нэвтэрч тулалдааны хувь заяаг шийдэж байсан юм. Тухайлбал, "Монголор" компанийн барилгад байсан хятад цэргийг цагаантны цэргүүд эзлэн авах үед хятад цэргүүд хариу их бууны галын дэмжлэгтэйгээр довтлоход монгол цэргүүд газрын бартааг ашиглан эгзэгтэй мөчид туслан уг барилгыг эзлэн авчээ. Ер нь монгол цэргүүд л хамгийн түрүүнд хүрээнд орж ирсэн түүхтэй бөгөөд 1921 оны 2 дугаар сарын 4-нд Барон Унгерны удирдлага дор Нийслэл хүрээг амжилттай чөлөөлжээ.

Бароны цэрэгт алба хааж байсан олон офицер хожим өөрийн дурдатгалдаа "...Монгол цэргийн эр зориг, байлдах чадварыг бахдан биширч байна. Монгол цэрэгтэйгээ хамт Лисабон хүртэл байлдсан ч чадахаар тийм их эр зориг хүсэл тэмүүлэлтэй байна. Тэд байгаагүй бол тулалдааны хувь заяа өөрчлөгдөх байсан" гэж дурссан байдаг.

Нийслэл хүрээний төлөөх тулалдаан үүгээр дуусаагүй юм. Улаан хадны тулалдаан, Чойрын байлдаан гээд Нийслэл хүрээг эргэн бүслэх гэсэн гамин цэргийн эсрэг монгол цэргүүд амжилттай байлдаж эрэлхэг гавьяа байгуулсан түүхтэй.

Бид Барон Унгерн Нийслэл хүрээг орос цэргийн хүчээр чөлөөлсөн мэтээр буруу ярьж бичих нь их бөгөөд түүний удирдлага дотор явж байлдсан монгол цэргүүдийнхээ гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлыг төдийлөн сайн мэдэхгүй байгаа нь харамсалтай зүйл юм. Тиймээс



хэмээн нэрлэгдэх үндэс болсон юм.

Азийн морьт дивиз Монголд нэвтрэн орж ирсний дараахан 1920 оны 10 дугаар сард Хүрээнд байсан Хятадын цэргийн удирдлагуудтай удаа дараагийн хэлэлцээ хийсэн

мэдэхийн хувьд тагнуул туршуул хийх, худалдаа наймаачин, мөргөлчний дүрээр Хүрээ рүү нэвтрэн цагийн байдлыг ямагт Бароны штабт мэдээлэх гол үүргийг гүйцэтгэсэн юм. Үүн дотроос хамгийн чухал ажил бол Бароны цэрэгт туслахаар

цаашид монгол цэргийн гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлыг нээн судлах нь зүйтэй бөгөөд энэ бүх түүхийг хэдхэн хуудсанд багтаан бичих гэж хичээсэн тул дараа дараагийн өгүүлэлдээ цуврал болгон нийтэлнэ.

Ж.Баянжаргал: ҮНЭЛШГҮЙ БАЯЛАГ, ДУҮРЭН АМЬСГАА АВАХ ГАНЦ ГАЗАР МИНЬ ЭХ ОРОН

Өөрийгөө танилцуулахгүй юу? Яагаад легионер болох замыг сонгосон юм бэ?

-Намайг Жаргалсайхан овогтой Баянжаргал гэдэг. 26 настай, барилгын инженер мэргэжилтэй. Францын армид 4 жил 3 сар алба хааж байна. Анх 16 настайдаа легионеруудын тухай олж мэдээд алба хаах зорилго тавьсан. Насны хязгаар 17.5-39.5 байдаг тул их сургуулиа төгсөөд 22-тойдоо легионер болсон. Хувь хүн талаасаа илүү хөгжин юм үзэж, нүд тайлж бас өөрийгөө сорьж үзэхийг хүссэн болохоор энэ армид элсэж легионер болохыг зорьсон.

Францын арми болон легионеруудын талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Францын армийн хувьд франц хүн бүр алба хаадаг. Легионы хувьд дэлхийн хаанаас ч ирж элсэн орж болно. Гэхдээ алба хаах хугацаандаа Францын армийн цэргийн алба хаагчид тооцогддог. Дэглэмийн хувьд сургалт бэлтгэл, үүрэг гүйцэтгэлт гээд олон зүйлээрээ Францын үндсэн армиас илүү. Зарим хүмүүс тусгай хүчинтэй нь андуурдаг.



Легионер болоход ямар шалгуур тавигддаг вэ?

-Анх элсэхдээ олон төрлийн сорилт өгдөг. Турникт суниах, гүйлт, усанд сэлэлт, IQ шалгасан хоёр төрлийн сорилоор шалгалт өгнө. Дээр нь хувь хүний болон тусгай (сэтгэлзүй шалгасан) гэсэн хоёр төрлөөр ярилцлага авдаг. Мэдээж эрүүл мэндийн хувьд маш нарийн шалгадаг. Эдгээрийг харгалзан авах эсэхээ шийддэг. Тэнцсэн тохиолдолд 4 сар карантин, дараа нь ангиа сонгоод дахин 2 сарын карантин гэх зэргээр үргэлжилдэг.

Сургалт бэлтгэлийн хувьд ямархуу байдаг вэ?

-Сургалт бэлтгэлийг өдөр бүр хийдэг. Ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, хөдөө хээр явах, харуул хийх үед ч ялгаагүй сургалт бэлтгэл явагддаг. Цэргүүдэд тавьдаг норматив гэж бий. Түүгээрээ жилд нэг удаа шалгалт авдаг. Дүрэмт хувцас, хэрэглэлтэйгээ 8 км гүйх, олонд авирах, усанд 15 метрийн гүнд шумбаж үргэлжлүүлээд 85 метр сэлэх, гар дээр цэвэр 55 суниах, 2400 метр гүйх зэрэг сорилыг тогтоосон хугацаанд өгдөг.

Дүрэмт хувцас, хэрэгслийн хангамжийн талаар сонирхуулахгүй юу? Нууц биш бол цалингаа хэлж болох уу?

-Хувцас, хангамжийн хувьд маш сайн. Жилийн хугацаанд хувцас захиалж болох оноо өгдөг. Түүгээрээ гутал, хувцас зэрэг ойр зуурын зүйлсээ авна. Ямар нэг ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хувцас, хэрэглэлийг нэмж олгодог. Цалингийн хувьд үндсэн цалин 1350 евро, даатгал зэрэг ойр зуурын зайлшгүй төлдөг зүйлсээ хасаад ойролцоогоор гар дээрээ авах нь 1200 евро. Ажиллагаа, хамгаалалт, хээрийн сургуулилт зэрэгт явахад тус бүртээ өөр өөр нэмэгдэл цалин бодогддог.

Монголоос хэдэн залуу алба хааж байна вэ? Эх орон гэж таны хувьд юу вэ?

-Албан ёсны тоогоор хэд гэдгийг нь сайн хэлж мэдэхгүй ч 120 хавьцаа байх. Эх орон гэж миний хувьд үнэлшгүй баялаг, дүүрэн амьсгаа авах ганц газар минь гэж боддог. Эх орон, элгэн саднаа санахаараа ихэвчлэн дуу сонсдог. Гитараа шүүрч аваад дуулдаг. Энд байгаа бүх залуус эх орноо их санаж, эх орон руугаа тэмүүлдэг. Ар гэр, ахуй амьдрал зэргээс шалтгаалаад буцах хугацааны хувьд өөр өөр. Төрсөн нутгаас илүү сайхан газар гэж хаана байх вэ дээ.

Чөлөөт цаг гарвал юу хийдэг вэ?

-Чөлөөт цагаараа зааланд тоглоно. Найз нөхөдтэйгөө уулзаж ярилцана. Блог ажиллуулдаг болохоор бичлэгээ хийж байршуулна гээд хийх зүйл их.

Таны ирээдүйн зорилгыг сонирхъё...


-Есдүгээр сард халагдаад эх орондоо очно. Монголдоо хийх зүйл их байна. Нас залуу, цус шингэн байгаа дээрээ хүмүүст аль болох эерэг нөлөөлөл үзүүлж, улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулъя гэж бодож байна.

Баярлалаа. Амжилт хүсье.

Х.ГАНЗУЛ

ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ ЛХАВААНЫ ДОРЖИЙН
МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

ЦАГИЙН САЛХИНД ГАНДАА НЬ ҮГҮЙ ЦЭНХЭР ДУРДАН



(Дурсамж)

**Цэнхэр дурдан алчуураа
Цэцэг навчаар гоёлоо доо
Цээжний янагаа санахад
Цэргийн хороо илхэн**

байна гээд мөн ч яруухан даа ... Цэрэг эрсийн зүрхний тольтод хадагдаж ард олны цээжинд амин аялгуу нь эгшиглэсээр он цаг өртөөлөн дуулагдсаар эдүгээ 80 шахам жил болжээ.

С.Батсүрэн, Ж.Энэбиш нарын судалгааны "Дуунаас-дуурь" хүртэл номонд бичигдсэнээр 1940 онд Х.Пэрлээгийн шүлгээр "Амрагийн дуу" дууны аяыг Лхадорж зохиосноор төд удалгүй эх орон даяар түгж өнөөг хүртэл хангинасаар байна гэжээ.

Бид бүгдийн чихийг дэлдийлгэж бараг л тагнайд амтагдах нь холгүй энэ шидэт дууны аялгууг зохиосон. Лхадорж гэж хэн бэ гэвэл мэдэх хүн цөөрчээ.

Намтар сөхвөл ...

Лхаваагны Дорж 1921 онд Дорнод аймгийн Матад сумын Чулуун хашаат хэмээх газар төрсөн билээ. Бага наснаас хөгжмийн урлагийг шимтэн сонирхож Дорнод аймгийн хөгжмийн клубт сайн дураар орж тэр үеийн алдарт хөгжимчин Буурал Цамбаар лимбэ, хуучир заалган суралцсан бөгөөд 1939 онд Улаанбаатар хотын урлагийн сургуульд суралцаж төгссөн байна.

Л.Дорж нь 1940 оноос Улаанбаатар хотын Залуучуудын Соёлын ордонд хөгжмийн багш, 1941 оноос Хязгаарын цэргийн дуу бүжгийн чуулгад хөгжимчин, удирдаачаар, 1954-1957 онд Ардын дуу бүжгийн Улсын чуулгад найрал хөгжмийн удирдаачаар ажиллаж, 1957-1961 онд Шанхайн Хөгжмийн дээд сургуульд хөгжмийн зохиолч мэргэжлээр суралцжээ. Үүнээс хойш Ховд аймгийн Хөгжимт драмын театрын хөгжмийн багш, зохиолчоор ажиллаж байв.

Түүний уран бүтээлийн зам

юм.

Монголын орчин үеийн зохиолчдын анхдагчдын нэг Монгол Улсын Төрийн шагналт эрдэмтэн, нэрт зохиолч, түүхч, академич Дамдины Пэрлээ. Хөдөөгийн гэх Д.Пэрлээ нь Халхын Сэцэн хан аймгийн Хөвчийн Жонон вангийн хошуу өнөөгийн Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт 1911 онд төржээ. Их зохиолч Д.Нацагдоржтой тохой залган сууж шүлэг зохиолоо бичиж эхэлсэн зохиолчдын нэг юм. Энэ эрхэм хүний бүтээл туурвилыг хэн хүнгүй мэдэх билээ.

Нөгөө жигүүр нь сайн дуучин юм. 1940-өөд онд Цэргийн Дуу Танцны Ансамблийн дуучин Г.Лхам "Цэнхэр дурдан алчуур"-ыг дуулж олонд түгээж эхэлсэн. Багшаасаа өвлөн авсан дуучин буюу Цэнхэр дурдангийн гэх тодотголтой гавьяат жүжигчин Балдандоржийн Төмөр тус уран бүтээлийг дуулан алдаршуулжээ.

1957 онд ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга К.Ё.Ворошилов манай оронд айлчлах үеэр Офицеруудын ордонд хүндэт зочин, нам, засгийн удирдагчдад зориулсан хүндэтгэлийн концертод анх дуучин Б.Төмөр гоцолж найрал дуучид дуулсан нь алдарших эхлэл болж, Монголын баримтат киноны хальсанд мөнхрөн үлдсэн юм.

Энэ дууны гоцлол, найрал дуучдад зориулсан найруулгыг Төрийн шагналт, УГЗ Д.Бадарч хийсэн нь уянгын дууны агуулгыг улам далайцтай болгож, эх орон, цэрэг эрсийн цог золбоо, хайр сэтгэлийн холбоог магтан дуулсан бүтээл болжээ.

Дуучин Б.Төмөрийн шавь Гавьяат жүжигчин Л.Цэрэнпил түүний охид Гавьяат жүжигчин Ч.Туул, Ч.Баярмаа нар дуулж өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй эгшиглэсээр байгаа нь ямар гайхамшигтай бүтээл гэдгийг

тасарсан.

"Амрагийн дуу"-ны тухай Төрийн шагналт, нэрт яруу найрагч С.Дашдооров дурсахдаа "“Амрагийн дуу” манай үеийнхний эх орныхоо өмнө хүлээсэн иргэн хүний чин санаа хүслийг бадраасан жинтэй уран бүтээл юм” гэсэн нь энэ дуунд өгсөн үнэлэлт юм.

Өдгөө 90 гаруй нас сүүдэр зооглож буй, цагтаа Хязгаарын ба Цэргийн ансамблийн гоцлооч, нэртэй дуучин асан буурал багш Гочоогийн Гэлэгжамц хуучлагдаа "Намайг 1946 онд Хязгаарын ансамбльд ороход Лхадорж хөгжмийн багш байсан. Мөн ч авьяастай хүн дээ. Бригадаар явж байхад машин дээр исгэрч харгадана. Нэг мэдэхэд л сайхан дуу зохиодог байсан. "Амрагийн дуу"-г Хязгаарын ансамблийн Тэрбиш гэж эмэгтэй анх дуулсан. Дараа нь залгаад Лхам дуулсан. Тэр үед дуунууд нь олон түмэнд түгж Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн нартай эн зэрэгцэж Маршал Х.Чойбалсангийн зохиолч гэж мандаж явсан даа.

Ховдын театрын Ерөнхий найруулагч асан Ардын жүжигчин Д.Гомбосүрэн дурсахдаа "Их л даруу хүн байсан. Ёстой нөгөө хорхойд хоргүй тийм л хүн. Би лав хүнтэй муудалцаж байхыг нь хараагүй. 1973 онд Ховд аймгийн Хөгжимт драмын театрын тайлан тоглолт Улаанбаатарт болоход Лха.Дорж багш концертын хамаг хөгжмийн найруулгыг хийж билээ.

1975 онд Д.Содномдоржийн цомнол, Лхадоржийн хөгжим "Атрын өглөө" хошин дуурийг тавихад би найруулагчаар ажилласан юм. Их сонин хүн. Төгөлдөр хуур дарж харагддаггүй. Шүдэнзний мод эгнүүлж тавиад няслаад, товшоод ая оруулдаг байсан. Их авьяастай. Гурван удаа гавьяатад тодорхойлуулаад авч чадаагүй дээ" хэмээсэн.

1990 оноос хойш Оросын



Зүүн гар талаас дөрөв дэх нь Б.Төмөр эмэгтэй уран бүтээлчдийн хамт

1939 онд зохиосон "Бид ялна" дуугаар эхэлсэн юм.

"Хилчин", "Одонт хороо", "Монгол морь", "Бат эгнээ" зэрэг цэргийн дуу "Эрхмийн дээд", "Сүү", "Эргэн хармаар санагдана" гэх зэрэг утга уянгын 70 гаруй дуу зохиосон нь энэ үед хамаарах болой. Монгол хүнд зовох жаргах алив цагт хань болж, хамт зүтгэдэг морин эрднийг магтсан "Монгол морь" нь хилийн чанадад хүртэл түгжээ.

Түүний "Эрхмийн дээд" дуу нь эх орны өнгө жавхаа, байгаль, хүн ардынхаа тэнүүн жаргалыг дуулсан шилдэг бүтээл билээ. Л.Доржийн 1940, 1950-аад оны нийтийн дууны уран бүтээлүүд дийлэнхдээ эх орондоо хайртай ард түмэн, цэрэг эрсийн дайчин бадрангүй үзэл нэвт шингэсэн, үргэлж урагш тэмүүлсэн байдгаараа онцлог юм.

Дуу гурван жигүүртэй гэвэл яахын аргагүй шүлэг нь нэг жигүүр

гэрчилнэ. Энэ алдарт дууг олон хүн дуулсан ч дуучин Төмөрийг давсан нь хэд бол. Энд нэгэн дурсамжийг дурсахгүй байхын аргагүй. 1974 оны 11 дүгээр сард намайг найруулагчаар Соёлын ордонд ажиллаж байхад 1975 оны шинэ жилийн баяраар манай соёлын ордны ёлка болж, "Аз жаргалын эрэлчин" хүүхдийн дуурийг зохиосон хөгжмийн зохиолч Ц.Сүхбаатар багш надтай зэрэгцэн сууж байв.

Сүхбаатар багшийн хажууд зузаан нүдний шилтэй, бууралтсан халимагтай бор хүн баянхуур татаад сууж байлаа. Сүхбаатар багш надад "Нөгөө алдарт Лхадорж гэдэг чинь энэ шүү дээ" гэснээр бид танилцаж билээ. Залуу ч байж, юу ч мэдэлгүй өнгөрсөн. Сүүлд сонсоход миний ажиллаж байсан Дархан, Шарын голын Соёлын ордонд нэг хэсэг хөгжмийн багшаар ажиллаж байсан сурагтай. Тэгээд л сураг

хэвлэлүүдээр "Дешевая популярность" гэсэн айхтар үг гарч ирлээ. Манай нэрт орчуулагч, Соёлын гавьяат зүтгэлтэн Ж.Нэргүй монголчлохдоо "Олигтой юм бүтээгээгүй мөртлөө од болохыг санаархагч гэх юм уу, "хямдхан алдарших" гэсэн утгатай гэж орчуулж байсан. Энэ цаг үед манайханд их л хамаатай үг байх.

Хөгжмийн зохиолч Лхавааны Дорж нь ХХ зууны Монголын хөгжмийн урлагийн нэрт төлөөлөгч, 1940-1950-аад онд зохиосон цэрэг-эх орны сэдэвт дуугаар ихэд алдаршсан нийтийн дууны мастер байсан юм.

Цэргийн чуулгыг "Цэнхэр дурдан"-гүйгээр төсөөлөхийн аргагүй. Мөнхөд үлдэх бүтээлийг зөвхөн алдартнууд туурвин бүтээгдийн нэг л жишээ нь энэ дуу юм.

**ЦДБЭЧ-ын найруулагч
асан С.БОЛД**



ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙГ АРИЛГАХАД ОРОЛЦСОН ЗЭВСЭГТ ХҮЧНҮҮДИЙН ТУРШЛАГА

(Түрүүч нь I нүүрт)

ГАИТИ УЛС 13 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ТУСЛАМЖ АВЧЭЭ



Дэлхийн түүхэнд бүртгэгдсэн байгалийн хамгийн том гамшгуудын нэг нь 2010 онд Гаити Улсад тохиолдсон 7 баллын хүчтэй цуврал газар хөдлөлт юм. Гамшгийн улмаас 250 мянган хүн нас барж, 300 мянган хүн хүнд болон хөнгөн гэмтэж, 1.5 сая хүн орон гэргүй болжээ. Газар хөдлөлтөд нийтдээ 3 сая хүн өртсөн бөгөөд 250 мянган барилга, байшин сүйдсэн байна. Гамшгийн голомт нь нийслэл Порт Ау, Жакмел хотыг дайрч, тус улсын Ерөнхийлөгчийн ордон, Парламентын ордон, сүмүүд, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа MINUSTAH-ийн төв байр зэрэг олон барилга, байгууламж өртөж, улс төрийн болон олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг өндөр албан тушаалтай 30 гаруй хүн нас барсны дотор MINUSTAH ажиллагааны удирдагч Хэди Анаби байсан юм.

Дэлхийг цочроосон байгалийн гамшигт туслахаар дэлхийн олон орон хандивын аян өрнүүлж, эрэн хайх, авран туслах, эмнэлэг, инженерийн болон бусад ажиллагааг эхлүүлсэн. АНУ-д "Гаитид итгэл найдвар хэрэгтэй" хандивын аяныг телевизийн эфирээр явуулсанд нь нэг өдрийн дотор 58 сая ам.долларыг цуглуулж чадсан байна. Энэхүү гамшгийн хохирлыг арилгахад зориулж АНУ-ын Зэвсэгт хүчний бүх төрлийн цэргээс бүрдсэн Нэгдсэн шуурхай хүчнийг байгуулж, командлагчаар нь дэслэгч генерал Кен Кийн томилогдож байв. Тэнгисийн цэргээс 17 хөлөг онгоц, 48 нисдэг тэрэг, бусад төрлийн 12

онгоц, 10 мянга гаруй усан цэрэг болон тэнгисийн явган цэрэг оролцжээ. Агаараар маш их хэмжээний тусламжийн ачаа тээвэрлэсэн бөгөөд энэ үүргийг АНУ-ын Агаарын цэргийн хүчин дангаараа гүйцэтгэсэн байдаг. Тэд газар хөдлөлтөөс хойш нийт 17 мянган цэргийг Гаитид хүргэж, сайн дурын 6000 ажилтныг тус улсад буулгажээ.

Гаити Улсын нисэх онгоцны буудлыг аюулгүй болгох, нислэгийн бүх хуваарийг зохицуулах ажлыг АНУ-ын Агаарын цэргийн хүчнийхэн хариуцаж байлаа. Гэвч тус улсын "Туссант Лувертур" нисэх онгоцны буудал нь тусламжийн ачаа тээвэрлэсэн онгоцнуудыг хүлээн авах ачааллаа дийлэхгүйн улмаас зарим онгоцыг Доминикан Улсад буулгаж, усан замаар ачааг тээвэрлэж байв. Мөн агаараас хүнс, эмнэлгийн хэрэгслүүдийг хаях замаар олон мянган хүнд тусламж үзүүлж чадсан. Тэнгисийн явган цэрэг, Үндэсний гвардын цэргүүд авран туслах ажиллагааг гүйцэтгэж, нурангид дарагдсан олон мянган иргэний амь насыг аварчээ. Гамшгийг арилгахад зориулж НҮБ болон бусад хандивлагч орнуудаас нийт 13 тэрбум ам.долларын тусламжийг үзүүлсэн ч одоог хүртэл гамшгаас үүдэж эвдэрч сүйдсэн барилгууд хэдэн мянгаараа байсаар байгаа аж. Гудамжинд амьдарч байгаа иргэдийн тоо өмнөхөөсөө гурав дахин багассан ч ядуурал, ажилгүйдэл тус улсад буурахгүй байна.

CNN

ЮНАНЬ МУЖИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТӨД 2500 ЦЭРЭГ ОРОЛЦСОН



Хятад улсын Юнань мужид 2014 онд 6.1 баллын хүчтэй, 10 километрийн радиустай үргэлжилсэн газар хөдлөлтийн дараах эрэн хайх, авран туслах ажиллагаанд 2500 цэрэг оролцжээ. Тус газар хөдлөлтийн улмаас 1800 гаруй хүн шархдаж, 400 гаруй хүн нас барж, 1200 байшин сүйрч, 30 мянга гаруй зам талбай, бусад эд зүйлс эвдэрчээ.

Байгалийн гамшиг болсны дараа үргэлжлүүлэн хүчтэй аадар бороо орж байсан тул авран туслах ажиллагаанд саад учруулж байв. "ССТВ" гэхэд 14 жилийн туршид тус улсад тохиогоогүй хүчтэй газар хөдлөлт боллоо хэмээн мэдээлж байжээ. БНХАУ-ын дарга Си Жинпин цэргүүдэд хандаж хэлэхдээ "Та бүхэн эх орон, ард түмнийхээ бүрэн бүтэн байдлын төлөө тангараг өргөсөн хүмүүс. Тиймээс иргэн бүрийг аврахын тулд бүх хүчээ дайчлаарай" гэсэн байна. Цэргүүд өндөр уулсын бүсэд үргэлжлэн орсон аадар бороотой үед орон сууцны нурангид дарагдсан 32 хүний амийг аварсны дотор таван настай хүү байсан бөгөөд энэ нь нэг дор хамгийн олон хүний амийг аварсан тохиолдол болжээ.

Цэргүүд Юнань мужийн уулсын бүсэд гацсан иргэдэд хүнс, эмнэлгийн тусламж үзүүлэхдээ өдөрт 30 гаруй км алхдаг байсан аж. Хятадын Ардын Чөлөөлөх Арми гамшиг болсон бүс нутагт 2000 майхан, 9000 хөнжил, гудас бусад дулаан хувцас хэрэглэлийг илгээж байжээ.

AFP

БАЛБЫН 10 ЦЭРЭГ ТУТМЫН НЭГ НЬ АВРАХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН



Балбын мянга мянган цэрэг 2015 онд газар хөдлөлтийн дараах эрэн хайх, аврах туслах ажиллагаанд оролцож олон мянган иргэнийг аварчээ. Энэ үеэр 4000 хүн нас барсан юм. Хятад, АНУ, Их Британи, Энэтхэг зэрэг орны эмч, сайн дурын ажилтнууд, тусламжийн хэрэгсэл, хүнсийг агаараар тээвэрлэн хүргэж байв.

Газар хөдлөлтийн үеэр 200 уулчин Эверестийн оргил руу авирч байхдаа цасанд боогджээ. Балбын цэргийн нисгэгч Тулси Гуатам "BBC" агентлагт өгсөн ярилцлагадаа "Газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас цасан нурангид боогдсон уулчдыг аврахын тулд эрсдэлтэй байдалтай олон удаа нүүр тулсан. Нэг удаагийн нислэгтээ хоёр л хүнийг татан гаргах боломжтой байсан тул олон удаагийн нислэг үйлдэж уулчдын амь насыг амжилттай аварч чадлаа" гэсэн юм.

Балбын Зэвсэгт хүчний хэвлэлийн төлөөлөгчийн мэдээлснээр газар хөдлөлтийн улмаас 7000 орчим хүн шархдаж, улс орон даяар мянга мянга хүн орон гэргүй болж, тэсгим хүйтэнд гадаа гурав хонож ус, хоол хүнс, эрчим хүчний хомсдолд оржээ. Тус улсын бүх төрлийн цэргээс бүрдсэн 10 мянган хүнтэй Нэгдсэн аврах анги гамшгийн үед дайчлагдан өндөр уулсын бүсэд самнах ажиллагааг эхлүүлсэн нь үр дүнгээ өгч, мянга мянган иргэнийг үхлийн аюулаас аврах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн АНУ цэргийн ачаа тээврийн "С-130" онгоцыг 40 ортой явуулын эмнэлэг болгон тоноглож, хүнд гэмтсэн хүмүүст яаралтай эмнэлгийн тусламж үзүүлсэн нь нэгэн онцлог үйл явдалд тооцогдсон юм.

AP

ПАКИСТАНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТӨД 3.3 САЯ ХҮН НЭРВЭГДЭВ

Пакистаны Кашмир мужид 2005 онд 7.6 баллын хүчтэй газар хөдөлж, хөрш зэргэлдээх Афганистан, Тажикстан, Хятадын бүс нутагт чичирхийлэл мэдрэгджээ. Энэхүү гамшиг нь 1935 оноос хойш Зүүн Хойд Азид тохиолдсон хамгийн аймшигтай газар хөдлөлт байсан юм. Кашмирын нийслэл Музафарабад голомтолсон хөнөөл нь хотын 70 хувийг эвдлэн сүйтгэжээ. Тус

хугацаа маш бага байсан аж. Ялангуяа сургууль, цэцэрлэгийн барилгад дарагдсан хүүхдүүд хоёрхон хоногийн дотор бүгд өлбөрч үхсэн байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Анан 2005 оны 10 дугаар сарын 20-нд мэдэгдэл хийхдээ "Хэрэв бид яг одоо хүчин чармайлтаа нэмэгдүүлэхгүй бол үхлийн хоёр дахь том давалгаа эхэлнэ. Хүмүүст эмнэлгийн

замын цэргийн 70 гаруй хувь нь оролцож, таван дивизед хуваагдан үйл ажиллагаагаа явуулжээ. Тэр дундаа зам харгуй хаагдсан нутгуудад цэргийн нисэхийн салбар бүрэн дайчлагдан, 50 мянган хүнийг аюулгүй газар оронд шилжүүлэн байршуулж чаджээ.

Мөн Афганистан Улсад байрлаж байсан АНУ-ын Хуурай замын болон Тэнгисийн явган



улсын Засгийн газрын мэдээллээс үзвэл, 87350 хүн нас барж, 3.5 сая хүн орон гэргүй болсон гэж мэдэгддэг ч албан бус тоогоор 100 мянган хүн нас барсан гэдэг. Хамгийн аймшигтай нь гамшгийн үед 19000 бага насны хүүхэд эндсэн юм. Мөн 250 мянган мал үрэгдэж, хагас сая гаруй зэрлэг амьтан үхжээ.

Гамшиг нь 10 дугаар сард тохиолдсон ба хүмүүс Рамадан сараа тэмдэглэн мацаг барьж байх үетэй давхцжээ. Тиймээс барилгын нурангид бөөнөөрөө дарагдсан хүмүүсийг аврах

тусламж, хоол хүнс, цэвэр ус, орон байр шаардлагатай. Одоогоор 120 мянган хүнийг аварсан нь хангалтгүй байна" гэж Пакистаны Засгийн газрыг шүүмжилсэн удаатай.

Кашмир нь уулсаар хүрээлэгдсэн өндөрлөг газарт байрладаг учир газар хөдлөлтийн улмаас бүх зам харгуй хаагдаж, уулсын бэл чулуу, шороонд хучигдсан нь аврах ажиллагаанд хамгийн их саад учруулж байжээ. Пакистаны Зэвсэгт хүчнээр удирдуулсан эрэн хайх, авран туслах ажиллагаанд Хуурай

цэргийн анги, нэгтгэлүүд, Их Британи Улсын Эзэн хааны нисэхийн багууд яаралтай тусламж үзүүлэн цэргийн тээврийн нисэх онгоц болон нисдэг тэрэг илгээж олон мянган хүний амь насыг аварсан юм. Тэд Энэтхэг, Пакистаны хилийн орчимд хяналтын бүс нээж, түүндээ гамшигт нэрвэгдсэн иргэдийг байрлуулж, хүмүүнлэгийн болон эмнэлгийн тусламжийг үзүүлсэн нь иргэдийн амь насыг аврах үр дүнтэй ажиллагаа болжээ.

BBC

ДУГААРЫН ЗОЧИН

Б.Сарантуяа: НҮД ТАЙЛЖ, ЧИХ ОНГОЙХ ТУСАМ МОНГОЛЫНХОО САЙХНЫГ МЭДЭРЧ ЭХЭЛСЭН

Дэлхийн 42 орноор аялсан үүргэвчтэй аялагч Б.САРАНТУЯАТАЙ та бүхнийг уулзуулж байна. Тэрээр "The Nomadic Soul" гарааны бизнес үүсгэн байгуулагч юм.

Гурван жилийн өмнө хэвлэлд өгсөн ярилцлагадаа 25 нас хүрэхээсээ өмнө 25 орноор аялна гэж хэлсэн байсан. Тэр зорилгодоо хүрсэн үү?

-Тэр зорилгодоо хүрсэн. 25 насны төрсөн өдрөө 25 дахь улс буюу Израйлд тэмдэглэсэн.

Эхлээд бизнесийн удирдлага мэргэжлээр сургууль төгсчихөөд дараа нь аялал жуулчлалын чиглэлээр суралцжээ. Хоббигоо мэргэжил болгосон хүн гэхээр их сонирхолтой санагдаж байна. Энэ талаар ярилцлагаа үргэжлүүлье ...

-2014 онд бизнесийн удирдлагаар бакалаврын зэрэг хамгаалсан. Их сургуулийн 4 дүгээр курст сурч байхдаа Индонезийн Засгийн газрын "Дармасисва" тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар материаллаа өгсөн юм. Энэхүү хөтөлбөр нь Индонези Улсын урлаг соёл, түүх, хэлийг олон улсад таниулах зорилготой бөгөөд тус улсын өнцөг булан бүрт байх 72 их сургуульд 180 гаруй улсын оюутнууд суралцдаг. Тус хөтөлбөрт материалаа өгөхөөр судалж байхад надад хамгийн их таалагдсан хөтөлбөр нь аялал жуулчлал байсан. Мөн аялал жуулчлал ихэд хөгжсөн Бали арал дээр сургууль маань байсан нь бүр ч их тааламжтай санагдаж, сонирхлыг минь татсан юм. Монголд их сургуулиа төгсөх үеэр тухайн тэтгэлэгт тэнцсэн хариу ирсэн. Ердөө хоёрхон сарын дараа Индонези руу суралцахад явж байлаа. Тухайн үед хамт суралцсан Португал, Мексик, Афганистан, Испани, Эквадор, Тайланд, Вьетнам зэрэг олон орны оюутнуудын нийтлэг сонирхол нь аялах. Тэднээсээ л их урам зориг авдаг байлаа. Аялалтай анх ийнхүү танилцаж, түүндээ дурлаж сүүлд нь хоббигоо ажил, мэргэжил болгосон доо.

Хамгийн анхны аялал хаанаас, хэзээ эхэлсэн бэ?

-Индонези улсаас. Эхэндээ хамт сурдаг тайланд найзтайгаа нийлж мотоцикл түрээслээд Бали арлын үзэсгэлэнтэй гэсэн газар бүрт очдог байсан. Эхлээд арлаа бүтэн тойроод, түүний дараа зэргэлдээх арал руу аялж үзсэн юм. Хичээлийн хоёрдугаар улирал эхлэхэд мөн л эквадор найзтайгаа үүргэвчээ үүрээд Индонезийн Жава арал руу аялсан. Тэр үед автобус, завь, мотоцикл, усан онгоц, замын унаа гээд олон төрлийн тээврийн хэрэгслээр явж, тусгай хамгаалалттай жижиг арал, галт уул, эртний хотууд зэрэг газрыг үзсэн дээ. Ингэхдээ майхан, зочид буудал, айлуудад байрлаж цагийг мөн л сонирхолтой

өнгөрүүлсэн. Маш хурдан болоод өнгөрсөн мэт санагддаг. Энэ аяллын үеэр л өөрийгөө аяллын цохонд хатгуулсан гэж боддог шүү /Иинээв/.

Мэдээж залуу хүнд ийм олон газраар аялахад санхүүгийн хүндрэл, бэрхшээл тулгарч байсан л байх. Хямд зардлаар олон орноор аялсан туршлагаасаа хуваалцахгүй юу?

-Оюутан байхдаа анх аялж эхэлсэн учраас орлого гэхээр зүйл байгаагүй. Тухайн үеийн санхүүгийн эх үүсвэр маань ерөнхийдөө тэтгэлэг байсан. Тиймээс бусад арлаар аялахын тулд хэрэглээгээ багасгах ёстойгоо ойлгосон. Дараа нь аль болох сул зардал гаргахгүй байхыг хичээж, өдөрт нэг удаа хоол идэх, нэмэлт зардлуудаа танах зэргээр цааш хийсээр хуримтлал үүсгэх боломж бүрдүүлдэг байлаа. Сургуулиа төгсөөд Монголдоо ирсний дараа дахин хэзээ, хаашаа аялах вэ гэсэн бодолд уягдах боллоо. Хурааж хуримтлуулсан хөрөнгөгүй учраас тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж, сайн дурын ажлууд хайж эхэлсэн юм. Олон ч хөтөлбөрт хамрагдахын тулд материалаа явуулсан. Үүний дүнд 2016 онд Итали Улсад зохион байгуулагдсан Дэлхийн оюутны тэшүүрийн аварга шалгаруулах тэмцээнд сайн дурын сэтгүүлчээр ажиллах хөтөлбөрт тэнцэж билээ. Гэвч Итали руу явахын тулд нислэгийн тийз худалдаж авах, нэмэлт зардлуудаа олох гээд л шил шилээ дарсан санхүүгийн асуудлууд тулгарсан. Азаар төгссөн сургуулиас маань нислэгийн зардалд мөнгө хандивлаж, би ч өөрийгөө завгүй байлгах болсон. Цагийн ажил хийхийн хажуугаар Монголд ажилладаг гадаадын иргэдэд монгол хэлний хичээл зааж, амралтын өдрүүдээр аяллын хөтөч хийдэг байлаа. Яг энэ үед л хүн өөрөө үнэхээр хүсэж дурлал болдог, бүтдэг гэдгийг маш сайн ойлгосон. Түүнээс хойш туршлагаасаа бусадтай хуваалцаж, аяллын хөтөлбөр гаргахад нь тусалж, өөрөө аялал зохион байгуулснаар илүү олон газарт хүрч очих боломж нээгдсэн гэж болно.

Аялж байхад тань эвгүй ч гэмээр санагдсан зүйл юу? Өөрөөр хэлбэл таагүй сэтгэгдэл төрүүлсэн зүйл ...

-Олон янзын авир араншин, хандлага үзүүлдэг хүнтэй таардаг. Таксинд суухад илүү мөнгө авахыг санаархаж, тойруу замаар явах, худалдан авалт хийхэд хууран мэхэлдэг гэх мэт. Гэхдээ тиймэрхүү тохиолдолд нөхцөл байдлыг ойлгоод хариу арга хэмжээ авч сурсан гэж



боддог. Азаар энэ дэлхийд сайн хүн муугаасаа олон байдаг юм байна лээ. Жингийн туухай дээр тавьж үзвэл сайхан дурсамж нь муухайгаасаа хавьгүй илүү.

Бүх аялал дурсамж үлдээсэн гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ хамгийн сайхан дурсамж төрүүлж, дахин очмоор санагдсан газар ...

-Хамгийн гүн сэтгэгдэл үлдээсэн нь Иран Улс. Яагаад ч юм бусад улстай харьцуулахад илүү өвөрмөц санагддаг. Маш дотно сэтгэгдэл төрүүлсэн гэхэд буруудахгүй. Иран руу явахыг санал болгосон, хямдхан тийз захиалж өгсөн, аялж байх үед гэртээ байлгасан, хоолны газар пиццагаар дайсан, замын унаанд дайгдаж, төөрч будилж явахад тусалсан хувь хүн, гэр бүл гээд сайхан сэтгэлтэй олон хүнтэй учирсан даа. Энэ нь магадгүй буцаж очиход минь нөлөөлөхийг үгүйсгэхгүй. Тэдний сайхан сэтгэл, зочломтгой зан нь бусад орны иргэдээс илүү дотно сэтгэгдэл төрүүлсэн шүү.

"The Nomadic Soul"-ийн талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Анх Европоор аялах үедээ бусад аялагчдын жишгийг дагаж нүүр хуудас нээсэн. Аялах чин хүсэл эрмэлзэлтэй, жирийн нэгэн охин үүргэвчээ үүрээд хямд төсөрхөн зардлаар хаана хүрч очиж байгаагаа мөн аялахыг хүссэн хүн бүрт ийм боломж бий

гэдгийг харуулах зорилготой нээсэн гэх үү дээ. Аяллын үед тохиолдсон адал явдал, мөнгөө хэмнэж буй арга, сонирхол татсан зүйлс гээд бүх тэмдэглэлээ нүүр номдоо нийтэлдэг байсан нь олон хүнд хүрсэн. Европын орнуудаар аялаад буцаж ирэх үед хүмүүс надаас дараагийн удаа хаашаа аялах, зөвлөгөө өгөх, баг бүрдүүлж явах эсэх зэргийг асуудаг боллоо. Тэгэхэд анх "Би хямд зардлаар аялах аргыг сурсан, хүмүүс ч үүнийг хүсэж байна. Тиймээс өөрийн сурсан арга, тэдгээр хүмүүсийн хүслийг нэг цэгт хүргэе" гэж бодсон. Ингээд л Зүүн өмнөд Ази, Европын 4-6 орноор богино хугацаанд хямд зардлаар аялах хөтөлбөрүүд боловсруулан, баг бүрдүүлж аялал зохион байгуулж эхэлсэн. Энэ нь "The Nomadic Soul"-ийн үндэс суурь болсон гэж боддог.

Аялаас авдаг мэдрэмжээс тань хуваалцаж. Тэр мэдрэмж таныг дараагийн аялал руу хөтөлдөг байх ...

-Тэр мэдрэмжийг илэрхийлэх нь хэцүү юм шиг санагдаж байна. Би хүүхэд байхын л их сониуч зантай. Шинэ улсад очих, шинэ хүмүүстэй танилцах, шинэ соёлд суралцах зэрэг нь тун сонирхолтой санагддаг. Энэ сониуч, эрэлч хайгуулч зан минь намайг аялалд хөтөлдөг болов уу.

Өөрийн улс орны давуу болон дутагдалтай талыг их бага гэлтгүй олж харсан л байх ...

-Өндөр хөгжилтэй орнуудаар аялж ирээд Монголоо их л голдож байсан. Хотжилт, дэд бүтэц муу, хүмүүс нь стресстэй зэргээс шалтгаалаад нэг л тааламжгүй санагддаг байв. Гэхдээ илүү олон орон, өөр газруудаар урт хугацаанд аялахын хэрээр нүд тайлж, чих онгойж Монголынхоо сайхан бүхнийг анзаарч, мэдэрч эхэлсэн. Бид өөрсдөө хичээвэл Монгол маань боломжоор дүүрэн улс гэдгийг хамгийн их ойлгосон.

Ганцаараа аялж байсан удаа цөөнгүй байх. Эмэгтэй хүн ингэж аялах хэцүү биш гэж үү, аюулгүй байдлаа бодсон ч тэр ...

-Ганцаараа аялахад төөрөх, айж эмээх үе цөөнгүй ч азаар муу зүйл тохиолдож байгаагүй. Хамгийн түрүүнд аяллын төлөвлөгөөгөө сайн гаргах хэрэгтэй. Мэдээж орой үдшийн цагаар аюултай газраар явахгүй, шинээр танилцаж байгаа хүмүүстээ хувийн мэдээллээ өгөхгүй байхад өөрийгөө эрсдэлээс тодорхой хэмжээнд сэргийлнэ гэсэн үг. Дуртай зүйлээ хийж байгаа хүнд зориг ундраад байдаг юм шиг санагддаг.

Аялал хийхэд зайлшгүй биедээ авч явах ёстой зүйлс юу вэ?

-Гадаад паспорт, олон улсын карт, бэлэн мөнгө, хувийн хэрэглээний зүйлс байхад хангалттай. Ялангуяа үүргэвчтэй аялахад нэг их зүйл хэрэггүй. Аяллын даатгал заавал хийлгэж байгаарай гэж зөвлөө.

Залуу байгаа дээрээ аял, зугаал, цаг бүү алд, хожим харамсана гэдэг ...

-Аялахад нас тийм ч чухал биш. Хүн бүр өөр өөр учраас. Залуудаа аялснаар шинэ содон зүйлстэй танилцах, амьдралыг харах өнцгөө өөрчлөх, дурсамж бүтээх гээд олон давуу талтай байх. Миний хувьд үлдсэн амьдралдаа харамсахгүй байх үүднээс залуу насандаа хүсдэг зүйлсээ хийгээд алдаж оноод, туршлагажаад нүдээ нээж, чихнийхээ бөглөөсийг гаргах хэрэгтэй гэж боддог. Хөгширсөн хойноо тэр үед тэгэх минь яв даа гэж харамсах нь утгагүй хэрэг.

Баян хүмүүс аялдаг гэсэн хэвшсэн ойлголтыг халж, бодитоор үлгэрлэсэн хүний хувьд байдал ер нь хэр өөрчлөгдсөн гэж үздэг вэ?

-Сүүлийн жилүүдэд энэ хэвшмэл ойлголтоос ангижирч байгаа гэж боддог. Хүн бүрийн амьдралыг үзэх үзэлтэй илүү холбоотой байх. Туршлагадаа тулгуурлаад хэлэхэд хүн үнэхээр хүсвэл хүссэндээ хүрэх боломж, арга зам заавал олддог.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ЭМГЭНЭЛ

ГОНЧИГИЙН БАТМӨНХ /1923-2021/

1939, 1945 оны дайнд оролцсон ахмад дайчин, чөлөөнд байсан хошууч Гончигийн Батмөнх тэнгэрийн оронд дэвшиж бидэнд хүнд гарз тохиолоо.

Тэрээр 1923 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Булган аймгийн "Ачуутын гол" гэдэг газар төржээ. Г.Батмөнх нь 15 нас хүртлээ эцгийн гар дээр хүмүүжээд 1938 онд Матадын 8 дугаар дивизийн хөгжмийн салаанд хөгжимчин болж, улмаар Халхын голын байлдааны үеэр эмнэлгийн албанд ажиллаж байв. Мөн 1943 онд Тамсагийн 6 дугаар дивизэд автын сургуульд сурч жолооч болж, 1945 оны Чөлөөлөх дайнд Долоннуур, Жэхэ хот хүртэл явж үүрэг гүйцэтгэжээ.

Дайны дараа Анагаах ухааны дунд, дээд сургууль төгсөж Дундговь аймаг томиллолтоор ажиллаж байгаад 1967 онд цэргийн албанд эргэн ирж Мотобуудлагын тусгай бригад, 036, 175, 120, 027 дугаар ангид эмч, албаны дарга, халуун ус, угаалгын отрядын дарга, Холбооны батальоны ар талын орлогч зэрэг албыг хашиж байгаад 1990 онд гавьяаныхаа амралтад гарсан юм.

Тэтгэвэрт гарсныхаа дараа ҮБХИС, Монгол цэргийн музей, "Соёмбо" сонин, "Бага баян" цэргийн амралт зэрэг байгууллагад гэрээгээр ажиллаж, өсвөр, залуу үеийг эх оронч үзэл санаагаар хүмүүжүүлэх, жанжин Д.Сүхбаатар зэрэг баатарлаг хүмүүсийн үйл хэргийг сурталчлан таниулахад өөрийн хүч хөдөлмөр, авьяас билгийг зориулсан нийгэм, олон нийтийн идэвхтэн, соён гэгээрүүлэгч, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан байв.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр засгаас үнэлж Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, "Алтан гадас", Цэргийн гавьяаны одонгоор хоёр удаа, ОХУ-ын Эх орны дайны ялалтын болон маршал Г.К.Жуковын ойн дурсгалын медалиудаар шагнаж байлаа.

Талийгаачийн эх орноо гэсэн халуун сэтгэл, ажилсаг хөдөлмөрч чанар, үлгэр дууриалтай амьдрал, элэгсэг дотно зан харилцаа бүхэн нь бидэнд мөнхөд дурсагдах болно.

БХЯ, ЗХЖШ, ЗХЖШ-ЫН АХМАДЫН ХОРОО, ДАЙНД ОРОЛЦОГСДЫН МОНГОЛЫН ХОРОО, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 084 ДҮГЭЭР АНГИ, АХМАДЫН ЗӨВЛӨЛ




Үндэсний бахархал,

ӨВ СОЁЛ

ХОЛБООНЫ НИСЭХ ОНГОЦНЫ АЖИЛЛАГАА

Лондон. 4 дүгээр сарын 16 /ТАСС/

Европ дахь Америкийн хүчний штабын уламжилсан нь. Америкийн сөнөөгч онгоцны том нэгтгэлүүд Германы түрэмгийлэн эзэлсэн улс ба мөн Герман дахь нисэх онгоцны 10 буудлыг дайрав гэнэ. Үүнд Берлиний орчим нисэх онгоцны буудлыг дайрч дайсны олон тооны нисэх онгоцны гэмтээж угстав. Дайрах үеэс тэнгэрийн байдал муухай байжээ. Нисэх онгоцны буудал дээр угсаан онгоцноос гадна агаарын байлдаанд дайсны 18 машиныг унагав.



Америкийн 30 сөнөөгч онгоц бааздаа эгэж ирсэнгүй гэнэ.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ТӨВ АРХИВ УЛААН-ОДОН СОНИН 1944.04.19. ДУГААР 86 /1870/. ХУУДАС 8

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

Эхийг "Соёмбо" сонини редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029